



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Баянцагаан сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/083/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2026.02.25</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: М.Алтантуяа Утас: 99061829 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn Аудитор: А.Адилзаяа Утас: 80870886 Цахим хаяг: Adilzayaa@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудит хийгдээгүй болно.	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Албан шаардлага.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан:procurement.bayankhongor@audit.gov.mn

2026.02.25 № 1124

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Баянцагаан сумын Засаг даргын тамгын газар нь 2025 онд Шинэ хөдөө төсөл, сумын ОНХС болон аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн нийт 286,035.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	203,621,161.28	234,801,624.36
33	АВЛАГА	16,812,043.28	14,417,178.36
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,697,043.28	4,417,178.36
335	Бусад авлага	13,115,000.00	10,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	13,115,000.00	10,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	186,809,118.00	220,384,446.00
351	Түүхий эд материал	120,847,250.00	117,727,250.00
35110	Тусгай зориулалттай материал	120,847,250.00	117,727,250.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	-	19,600,000.00
354	Хангамжийн материал	36,879,368.00	53,974,696.00
35410	Бичиг хэргийн материал	1,045,530.00	1,245,530.00
35420	Аж ахуйн материал	31,403,838.00	47,857,166.00
35440	Түлш, шатах тослох материал	1,430,000.00	-
35450	Барилгын засварын материал	3,000,000.00	1,000,000.00
35470	Бусад хангамжийн материал	-	3,872,000.00
35500	Биологийн хөрөнгө	1,962,500.00	1,962,500.00
35600	Мал амьтад	27,120,000.00	27,120,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,654,059,908.10	3,033,082,993.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,654,059,908.10	3,033,082,993.20
392	Биет хөрөнгө	2,618,627,908.10	2,997,650,993.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,139,715,105.10	2,167,755,105.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(483,990,988.26)	(482,269,296.01)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	310,602,577.67	448,207,777.67
39204	Хуримтлагдсан элэгдэл	(124,946,466.66)	(127,017,530.87)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	192,904,742.73	219,314,008.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	(113,392,262.98)	(100,727,861.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	61,258,631.00	84,386,061.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,617,135.10)	(18,213,808.39)
39214	Бусад үндсэн хөрөнгө	778,999,192.30	910,329,192.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	(181,437,677.70)	(163,644,845.07)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	58,490,900.00	58,490,900.00
39217	Ном	1,041,290.00	1,041,290.00
393	Биет бус хөрөнгө	35,432,000.00	35,432,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	35,907,000.00	35,907,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(475,000.00)	(475,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,857,681,069.38	3,267,884,617.56
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,685,206.00	20,387,352.97
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,685,206.00	20,387,352.97
413	Өглөг	3,685,206.00	20,387,352.97
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,965.00	1,031,302.97
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	18,704,350.00
4136	Бусад өглөг	3,679,241.00	651,700.00
41361	Байгууллагад төлөх өглөг	3,679,241.00	651,700.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,853,995,863.38	3,247,497,264.59
51	Засгийн газрын хувь оролцоо	2,853,995,863.38	3,247,497,264.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	398,727,817.78	398,727,817.78
51101	Өмч: - төрийн	398,727,817.78	398,727,817.78
512	Хуримтлагдсан үр дүн	2,389,231,238.05	2,782,732,639.26

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	2,389,231,238.05	2,389,231,238.05
51220	Тайлант үеийн үр дүн	-	393,501,401.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	66,036,807.55	66,036,807.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,857,681,069.38	3,267,884,617.56

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,795,930,382.40	1,539,730,544.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	666,209,447.90	298,871,658.00
120	Нийтлэг татварын бус орлого	666,209,447.90	298,871,658.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,438,120.00	463,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,438,120.00	463,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,129,720,934.50	1,240,858,886.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	6,826,486.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	6,826,486.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,559,434.50	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,559,434.50	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,108,161,500.00	1,234,032,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,108,161,500.00	1,234,032,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,217,255,507.22	1,143,091,768.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,217,255,507.22	1,143,091,768.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,123,882,635.08	1,033,079,208.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	572,376,098.95	707,580,748.87
210101	Үндсэн цалин	275,267,282.55	409,338,984.64
210102	Нэмэгдэл	281,902,404.40	267,713,199.22
210104	Урамшуулал	15,206,412.00	30,528,565.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,578,745.85	88,029,446.98
210201	Тэтгэврийн даатгал	49,478,545.65	60,265,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,730,020.90	7,090,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,865,010.46	3,545,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,695,753.77	3,413,871.14
210205	Эрүүл мэндийн даатгал	10,809,415.07	13,714,975.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,747,677.74	47,193,296.00
210301	Гэрэл, цахилгаан	11,208,681.74	15,035,812.00
210302	Түлш, халаалт	16,538,996.00	31,157,484.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	77,931,281.70	97,915,654.30
210401	Бичиг хэрэг	4,390,400.00	3,391,550.00
210402	Тээвэр, шатахуун	32,851,543.90	31,768,933.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,316,000.00	4,082,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	37,256,037.80	52,718,671.30
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,117,300.00	5,954,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,270,700.00	14,053,050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,590,000.00	7,053,050.00
210604	Урсгал засвар	9,680,700.00	7,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	10,141,000.00	10,240,000.00
210702	Дотоод албан томилолт	10,141,000.00	10,240,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,957,871.19	21,208,879.00

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,336,178.19	18,805,287.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	299,812.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	204,592.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	250,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,267,000.00	649,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	254,881.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	319,879,259.65	46,858,133.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	125,431,138.00	28,437,763.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,600,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	188,848,121.65	18,420,370.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,372,872.14	110,012,559.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,786,326.50	1,895,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,895,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,286,326.50	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	75,586,545.64	108,117,559.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	75,586,545.64	108,117,559.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	578,674,875.18	396,638,775.71
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	12,500,523.54	3,137,374.50
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,935,523.54	3,137,374.50
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	10,565,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(12,500,523.54)	(3,137,374.50)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	566,174,351.64	393,501,401.21

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,131,159,054.50	1,244,437,786.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,438,120.00	463,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,438,120.00	463,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,438,120.00	463,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,438,120.00	463,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,129,720,934.50	1,243,973,886.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	9,941,486.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	9,941,486.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,559,434.50	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,559,434.50	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,108,161,500.00	1,234,032,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,108,161,500.00	1,234,032,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,005,151,454.50	1,129,892,586.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,005,151,454.50	1,129,892,586.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	911,778,582.36	1,019,880,026.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	569,897,306.24	707,677,063.26
210101	Үндсэн цалин	346,102,906.79	409,435,299.03
210102	Нэмэгдэл	204,652,137.70	267,713,199.22
210104	Урамшуулал	19,142,261.75	30,528,565.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,535,625.68	88,625,800.00

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	50,474,627.20	60,265,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,715,270.85	7,090,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,857,634.18	3,545,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,692,337.49	3,545,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,795,755.96	14,180,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,737,677.74	45,773,206.00
210301	Гэрэл, цахилгаан	10,707,665.74	13,305,422.00
210302	Түлш, халаалт	21,030,012.00	31,467,784.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	71,754,558.70	90,722,438.00
210401	Бичиг хэрэг	3,605,100.00	2,608,050.00
210402	Тээвэр, шатахуун	25,789,373.50	22,728,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,368,800.00	3,474,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	40,403,985.20	57,637,988.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	587,300.00	4,273,500.00
2105	Нормативт зардал	-	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,982,100.00	15,720,250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	191,400.00	9,630,250.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	1,000,000.00
210604	Урсгал засвар	14,790,700.00	5,090,000.00
2107	Томилолт, зочны зардал	10,141,000.00	10,240,000.00
210702	Дотоод албан томилолт	10,141,000.00	10,240,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,831,396.00	22,410,958.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,122,015.00	19,400,166.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	822,500.00	800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,000.00	204,592.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	250,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	1,256,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	274,881.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	104,898,918.00	37,710,311.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	104,898,918.00	37,710,311.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,372,872.14	110,012,559.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,786,326.50	1,895,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,895,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,286,326.50	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	75,586,545.64	108,117,559.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	75,586,545.64	108,117,559.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	126,007,600.00	114,545,200.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	126,007,600.00	114,545,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	126,007,600.00	114,545,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	126,007,600.00	114,545,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	126,007,600.00	114,545,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(126,007,600.00)	(114,545,200.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	398,727,817.78	66,036,807.55	2,389,231,238.05	00.00	2,853,995,863.38
D01	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	398,727,817.78	66,036,807.55	2,782,732,639.26	00.00	2,853,995,863.38
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	398,727,817.78	66,036,807.55	2,782,732,639.26	00.00	2,853,995,863.38
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	393,501,401.21	00.00	393,501,401.21
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	398,727,817.78	66,036,807.55	2,782,732,639.26	00.00	3,247,497,264.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,235,032,400.0	1,126,378,740.3	108,653,659.7	91.2
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,234,032,400.0	1,125,914,840.3	108,117,559.7	91.2
132001	Орон нутгийн төсвөөс	1,234,032,400.0	1,125,914,840.3	108,117,559.7	91.2
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.0	463,900.0	536,100.0	46.4
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.0	463,900.0	536,100.0	46.4
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,235,032,400.0	1,126,378,740.3	108,653,659.7	91.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,235,032,400.0	1,126,378,740.3	108,653,659.7	91.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,231,532,400.0	1,124,483,740.3	107,048,659.7	91.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	709,006,000.0	707,677,063.3	1,328,936.7	99.8
210101	Үндсэн цалин	409,435,300.0	409,435,299.0	1.0	100.0
210102	Нэмэгдэл	268,365,300.0	267,713,199.2	652,100.8	99.8
210104	Урамшуулал	31,205,400.0	30,528,565.0	676,835.0	97.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,625,800.0	88,625,800.0	0.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	60,265,400.0	60,265,400.0	0.0	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	7,090,100.0	7,090,100.0	0.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,545,100.0	3,545,100.0	0.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,545,100.0	3,545,100.0	0.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	14,180,100.0	14,180,100.0	0.0	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,210,700.0	46,178,206.0	4,032,494.0	92.0
210301	Гэрэл, цахилгаан	13,500,000.0	13,305,422.0	194,578.0	98.6
210302	Түлш, халаалт	35,710,700.0	31,872,784.0	3,837,916.0	89.3
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.0	1,000,000.0	0.0	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	101,094,800.0	86,361,748.0	14,733,052.0	85.4
210401	Бичиг хэрэг	6,600,000.0	2,608,050.0	3,991,950.0	39.5
210402	Тээвэр, шатахуун	30,600,000.0	21,632,410.0	8,967,590.0	70.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,684,600.0	3,324,800.0	359,800.0	90.2

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	58,210,200.0	57,637,988.0	572,212.0	99.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.0	1,158,500.0	841,500.0	57.9
2105	Нормативт зардал	1,000,000.0	1,000,000.0	0.0	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.0	1,000,000.0	0.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,069,000.0	34,865,550.0	28,203,450.0	55.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	27,500,000.0	23,275,550.0	4,224,450.0	84.6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.0	1,000,000.0	0.0	100.0
210604	Урсгал засвар	34,569,000.0	10,590,000.0	23,979,000.0	30.6
2107	Томилолт, зочны зардал	11,000,000.0	10,240,000.0	760,000.0	93.1
210702	Дотоод албан томилолт	11,000,000.0	10,240,000.0	760,000.0	93.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	158,231,500.0	113,810,858.0	44,420,642.0	71.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	152,109,000.0	110,800,066.0	41,308,934.0	72.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.0	800,000.0	0.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.0	500,000.0	0.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	522,500.0	204,592.0	317,908.0	39.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	300,000.0	250,000.0	50,000.0	83.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,500,000.0	1,256,200.0	2,243,800.0	35.9
210807	Газрын төлбөр	500,000.0	0.0	500,000.0	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,294,600.0	35,724,515.0	13,570,085.0	72.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,294,600.0	35,724,515.0	13,570,085.0	72.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,500,000.0	1,895,000.0	1,605,000.0	54.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,500,000.0	1,895,000.0	1,605,000.0	54.1
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,500,000.0	1,895,000.0	1,605,000.0	54.1
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24	23	1	95.80
620001	Удирдах ажилтан	8	8	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16	15	1	93.75
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9	0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	7	1	87.50
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7	0	100.0

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл /төгрөгөөр/
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,941,486.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,941,486.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,941,486.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,955,690.00
210402	Тээвэр, шатахуун	690,690.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,115,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,985,796.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,985,796.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,941,486.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,941,486.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,486,486.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,455,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газар нь Монгол Улсын Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжүүлэх, сумын орон нутгийн нийгэм эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх, хууль ёсыг чандлан сахиулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх зорилготой Баянцагаан сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа байгууллага юм.

Тус байгууллага нь 2025 онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт 75 арга хэмжээ тусган хэрэгжүүлж, гүйцэтгэлийг 78.1 хувьтай гэж үнэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын дотоод аудит/аудиторын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт-дотоод аудитын газар хэрэгжүүлдэг ба тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Төсвийн тухай хууль” болон бусад холбогдох хууль, журмуудыг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Байгаль орчны газар нь 2025 оны санхүүгийн тайланг “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянцагаан сумын Засаг даргын тамгын газар нь 2025 оны байгууллагын бүтэц орон тоог даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар 24 орон тоотойгоор баталж, гүйцэтгэлээр 23 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 410,203.6 мянган төгрөгөөр буюу 12.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	16,812.04	14,417.18	(2,394.86)
Бараа материал	186,809.12	220,384.45	33,575.33
Үндсэн хөрөнгө	2,654,059.91	3,033,082.99	379,023.09
Хуримтлагдсан элэгдэл	(924,859.53)	(892,348.34)	32,511.19
Нийт хөрөнгө	2,857,681.07	3,267,884.62	410,203.55
Өр төлбөр	3,685.21	20,387.35	16,702.15
Цэвэр хөрөнгө/өмч	2,853,995.86	3,247,497.26	393,501.40
Засгийн газрын хувь оролцоо	2,853,995.86	3,247,497.26	393,501.40
Тайлант үеийн үр дүн	-	393,501.40	393,501.40
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	66,036.81	66,036.81	-
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмийн дүн	2,857,681.07	3,267,884.62	410,203.55

Авлагын дансны үлдэгдэл 2,394.9 мянган төгрөгөөр буурсан нь оны эхний авлагын үлдэгдлээс өвс тэжээлийн авлага 3,115.0 мянган төгрөг барагдаж, НДШ, ҮЭ-ийн илүү төлсөн авлага 720.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд бараа материал дансны үлдэгдэл 220,384.5 мянган төгрөг болж өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа материал 101,422.9 мянган төгрөг, сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 8 дугаар хуралдааны 2 дугаар тогтоолоор сумын ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан 11,256.0 мянган төгрөгийн аж ахуйн материал болон сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 8 дугаар хуралдааны 2 дугаар тогтоолоор 1,116.1 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, үндсэн үйл ажиллагаанд 80,219.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага					
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	781,044.6	734,310.1	46,734.5	94.0
2	80106 Баг, хорооны үйл ажиллагааны зардал	194,774.0	187,123.1	7,650.9	96.1
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	3,500.0	1,895.0	1,605.0	54.1
4	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	49,294.6	35,724.5	13,570.1	72.5
5	81518 Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зардал	53,500.0	53,500.0	-	100.0
6	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	95,609.0	56,518.1	39,090.9	59.1
7	82212 Хур хог хаягдал, орчны бохирдлыг зайлуулах	57,310.2	57,308.0	2.2	100.0
Нийт		1,235,032.4	1,126,378.7	108,653.7	91.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.2 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь 2024 онд аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ийн үнэлгээгээр 3 дугаар байранд орсон тул үнэлгээний урамшуулал 4,000.0, өмнөх оны авлага 3,115.0 мянган төгрөг, мал тооллогын санхүүжилт 2,826.5 мянган төгрөг, нийт 9,941.5 мянган төгрөгийн орлого төвлөрч, тайлант хугацаанд бүрэн зарцуулсан байна.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянцагаан сумын ЗДТГ нь 2025 онд 50,000.0 мянган төгрөгийн автомашин, 22,000.0 мянган төгрөгийн шатахуун худалдан авах төлөвлөгөө батлуулж, гүйцэтгэлээр түлш шатахуун нийлүүлэх ажилд гүйцэтгэгчээр НИК ХХК шалгарч зээлээр газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх Т-25/17 дугаартай гэрээг байгуулж ажилласан байна. Автомашин худалдан авах ажиллагааг Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газраас “Зарим сумдад шаардлагатай автомашинд дэмжлэг үзүүлэх” БХАХААГ/20250102026 дугаар бүхий худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 31 дүгээр зүйл 31.1.1-т заасны дагуу нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан байна. Тус тендерт Буянт хөрс наран ХХК шалгарсны дагуу 25 дугаартай гэрээ байгуулан гэрээний 2.1-т Баянцагаан сумын ЗДТГ-аас 50,000.0 мянган төгрөгийг санхүүжүүлж, үлдэгдэл санхүүжилтийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр зааж, автомашиныг хүлээн авч, хөрөнгөд бүртгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Адилзаяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 463 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны 3 дугаар улирлын байдлаарх батлагдсан төсөвт зардал болох 880,982.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,809.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Аудитыг төлөвлөх үе шатанд тус байгууллагад хамаарах Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой 62 эрсдэлийг сонгож бүртгэснээс аудитыг гүйцэтгэх явцад тус хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8 дахь заалтыг зөрчсөн 1 зөрчил илэрсэнд зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт мэдээлбэл зохих цалингийн зардлаас бусад 5 саяас дээш дүнтэй орлогын 1,190,153.5 мянган төгрөгийн 38 гүйлгээ, зарлагын 245,176.5 мянган төгрөгийн 13 гүйлгээ мэдээлхээс орлогын 810,581.5 мянган төгрөгийн 23 гүйлгээ, зарлагын 5,000.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй байсныг завсрын аудитаар нөхөн мэдээлсэн болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитыг 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр гүйцэтгэсэн ба аудитаар 932,581.5 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснийг бүрэн залруулж, зөрчлийг арилгасан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2024 оны санхүүгийн тайлангийн аудитыг Төрийн аудитын байгууллагын аудитор Н.Бунчинсүрэн гүйцэтгэсэн бөгөөд аудитаар 1,628.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 102,824.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, тайлант хугацаанд бүрэн биелсэн байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,628.6	1	1,628.6	100
Албан шаардлага	3	102,824.0	3	102,824.0	100
Нийт дүн	4	104,452.6	4	104,452.6	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 117,000.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг завсрын аудитаар залруулав. Үүнд:

1. ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 8/52 дугаар тогтоолоор хүлээн авсан Prado-150 автомашиныг тоног төхөөрөмжийн дансанд бүртгэсэн байсныг тээврийн хэрэгслийн дансанд бүртгэж залруулав.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Аж ахуйн нэгж, байгулага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.3 дахь жинхэнэ хэрэгжилтийн;” 5.1.4 дэх “үнэн зөв байх;” УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, НББОУС-16 Үндсэн хөрөнгө, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2-т “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” гэсэн заалтуудад нийцэхгүй байна

Аудитаар нийт 450.0 мянган төгрөгийн 1 зөрчил² илэрсэнд зөрчлийг таслан зогсоох 450.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс материаллаг зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

5.1.1 Тайлант онд Засаг даргын 2025 оны А/08 дугаар захирамжаар "Могой жилийн сар шинийн барилдаан" зохион байгуулж 450.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.8 дахь “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийн таслан зогсоох, цаашид Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой арга хэмжээг төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх, биелэлтийг нотлох баримтын хамт 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд Засаг даргын 2025 оны А/08 дугаар захирамжаар "Могой жилийн сар шинийн барилдаан" зохион байгуулж 450.0 мянган төгрөг зарцуулсан байна.	1	450.0			1	450.0		
Дүн	1	450.0			1	450.0		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----